

**“МОНГОЛ ШУУДАН” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 01 дүгээр
сарын 28-ны өдөр


Дугаар 2016/02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус
хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.4 дэх заалт, 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, 67 дугаар зүйлийн 67.1 дэх заалт, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь заалт, 79 дүгээр зүйлийн 79.2 дахь заалт, 81 дүгээр зүйлийн 81.5.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 34-р тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. “Монгол Шуудан” хувьцаат компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 34%-ийг олон нийтэд хувьчилсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох, компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 10:00 цагт “Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим”-ын хурлын их танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй:
 - 2.1 “Монгол Шуудан” хувьцаат компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
 - 2.2 “Монгол Шуудан” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2016 оны 2 дугаар сарын 15-ний өдрийн 17:00 цагаар тогтсугай.

- 
4. Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг хавсралт №1-ийн дагуу баталж, 2016 оны 2 дугаар сарын 01-ний дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-нд хүргүүлэх, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зар”-ыг хавсралт №2-ын дагуу баталж, 2016 оны 2 дугаар сарын 02-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, мөн уг зарыг 2016 оны 2 дугаар сарын 17-ний өдөр анх мэдээлсний дагуу дахин хурлын зар хүргэхээр тогтсугай.
 5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан дараах бичиг баримтыг 2016 оны 2 дугаар сарын 07-ны дотор хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер дилерийн компанид хүргүүлсүгэй.
Үүнд:
 - ◆ “Монгол Шуудан” хувьцаат компанийн хувьчлалын үр дүнгийн талаар танилцуулга
 - ◆ “Монгол Шуудан” хувьцаат компанийн дүрмийн төсөл /нэмэлт өөрчлөлт оруулах/
 - ◆ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудас
 - ◆ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэг
 - ◆ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт
 - ◆ Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
 - ◆ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолын төсөл
 6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвших шаардлагыг хангасан нэр дэвшигчдийн материалыг хүлээн авч “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал”-д нэр дэвшүүлэхийг “Нэр дэвшүүлэх хороо”-нд даалгасугай.
 7. Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу саналын хуудсыг хавсралт №3-ийн дагуу баталсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын саналыг брокер дилерийн компаниар дамжуулан авах сүүлчийн өдрийг 2016 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөр тогтсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар О.Сэр-Одыг томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссыг хавсралт №4-ийн дагуу томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



О.СЭР-ОД